



МОНГОЛ УЛС
УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 141

Улаангом.

Биеийн тамир, спортын газрын бүтэц,
орон тоо, зохион байгуулалт, дүрэм
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Биеийн тамир, спортын газрын бүтэц, орон тоог нэгдүгээр хавсралтаар, зохион байгуулалтыг хоёрдугаар хавсралтаар, дүрмийг гуравдугаар хавсралттаар тус тус баталсугай.

2. Батлагдсан бүтэц орон тоог 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Биеийн тамир спортын газрын дарга /Б.Ганболд/-д даалгасугай.


3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/118 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.БАТСАЙХАН

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын
2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 04 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаал	Ангилал зэрэглэл	Орон тоо
Захиргаа, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийн алба-15			
1	Дарга	T3-9	1
2	Бодлого төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн	T3-6	1
3	Өсвөр үе, залуучууд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
4	ББТТС, албан байгууллага, сум хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
5	Биеийн тамир, спортын сургалт суртчилгаа, мэдээлэл технологи, заал хариуцсан менежер	TУ-7	1
6	Нягтлан бодогч	TУ-8	1
7	Архив, бичиг хэргийн эрхлэгч /нярав/	TУ-5	1
8	Заал зохион байгуулагч	TУ-5	1
9	Жижүүр	TУ-1	4
10	Үйлчлэгч	TУ-1	3
Сургалт, дасгалжуулалтын алба-6			
1	Сургалт хариуцсан ахлах дасгалжуулагч	TУ-7	1
2	Жудо бөхийн дасгалжуулагч	TУ-6	1
3	Чөлөөт бөхийн дасгалжуулагч	TУ-6	1
4	Спортын тоглоомын дасгалжуулагч	TУ-6	1
5	Хөнгөн атлетик, аэробик хариуцсан дасгалжуулагч	TУ-6	1
6	Эрүүл мэнд, фитнес, бодибилдингийн дасгалжуулагч	TУ-6	1
Нийт			21

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын
2018 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн 001 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

